

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- 1. Барааны тодорхойлолт:** [Багц-1. Мах, дайвар бүтээгдэхүүнд худалдан борлуулахаар зөвшөөрөгдсөн бүх төрлийн мах, амьтаны мах орно. Хиам болон лаазалсан, дахин боловсруулсан махан бүтээгдэхүүн хамаарахгүй, Багц-2. Сүү, сүүн бүтээгдэхүүнд хуурай болон шингэн сүү, тараг, аарц хамаарна, Багц-3. Бусад хүнсний бүтээгдэхүүн, Үүнд: Гурил, гурилан бүтээгдэхүүнд бялуу, кекс хамаарахгүй, төмс, хүнсний ногоонд дарсан ногоо буюу лаазалсан, дахин боловсруулсан бүтээгдэхүүн хамаарахгүй, будаа гэдэгт бүх төрлийн будаа, хүүхдийн будаа, үр тариа, шхр буурцгийн гаралтай бүтээгдэхүүн хамаарна, жимс, жимсгэнэ гэдэгт компот, хатаасан жимс хамаарахгүй, бусад гэдэгт давс, элсэн чихэр, ургамлын тос, масло, амтлагч, цай, исгэгч орно.]
Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуй нэгж /дэлгүүр/ нь:
 - Худалдааны газрын үйлчилгээ MNS 5021:2004 улсын стандартыг мөрдөж хэвшсэн байх
 - Үйлчилгээний зориулалтаар зохион байгуулсан худалдааны заалны хэмжээ 41 м2-аас багагүй байх
 - Шаардлага хангасан хүнсний агуулах, зориулалтын хөргөгч, хөргүүртэй байх
 - Үүдны хэсэгт тохижилт, гэрэлтүүлэгтэй энгийн хаяг тавьж зүлэгжүүлсэн байх
 - Жин хэмжүүр нь баталгаажсан, хугацаа дуусаагүй байх
 - Ариун цэвэр, ахуйн хангамжийн өрөө, халаалтын асуудлыг шийдсэн байх
 - Худалдаалж буй барааны нэр төрөл олон, сонголт их байх
 - Барааны баталгаажилт, шинжилгээний иж бүрдэлтэй байх
 - Худалдагч мэргэжлийн, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдсан эрүүл, ажлын хувцас, энгэрийн тэмдэг, нэрийн хуудсыг зүүж хэвшсэн байх зэрэг шаардлагууд, барааны эргэлт, санхүүгийн чадавхи зэргийг харгалзан үзнэ.
 - Байнгын татвар төлөгч байх
 - НӨАТ-ийн суутган төлөгчөөр бүртгэгдсэн Татварын гэрчилгээтэй байх
- 2. Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа худалдааны газрын болон нийлүүлэх нэр төрлийн бүтээгдэхүүний тус бүрийн стандарт, мөн бүтээгдэхүүний тээвэрлэлт, сав баглаа боодлын стандартын шаардлага хангасан байна.]
- 3. Бүтээгдэхүүн нь:** Мэргэжлийн хяналтын газрын үнэлгээ, дүгнэлттэй байх
- 4. Байгууллага, аж ахуй нэгж нь:** Ажлын байрны үнэлгээтэй байх
Е баримт хэвлэдэг машинтай байх
Баталгаажсан жин хэмжүүртэй байх
- 5. Баглаа, боодол:**
 1. [Барааг хэлбэр хэмжээ, жин, ачиж буулгах, тээвэрлэх нөхцлийг цаг уурт харгалзуулан бат бөх, урагдаж эвдрэхгүй цэвэр нямбай савлаж бэлтгэн нийлүүлэх
 2. Нийлүүлэгдэх барааны чанар стандартыг бүрэн хангасан байх, бараа авдаг газрын тодорхойлолт, гарал үүслийн гэрчилгээг хавсаргах
 3. Буруу шошголсон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдаалаагүй байх
 4. Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгонд агуулагдах мэдээлэл монгол, орос, англи хэлний аль нэг дээр бичигдээгүй байх
 5. Худалдааны газар өөрөө жижиглэн савласан бол хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгын мэдээлэл нь шаардлага хангасан байх
 6. Хүнсний зориулалтын сав, баглаа боодолд савласан байх
 7. Зарим нэр төрлийн барааг хоёрдогч гуравдагч этгээдээс авч нийлүүлж байгаа бол хамтарлын гэрээний хуурбарыг хавсаргах]
- 6. Бараа хүргэх газар:** [Уянга сумын 2 дугаар цэцэрлэг]